Хууль зүй, дотоод хэргийн яамны
2026 оны 01 дүгээр сарын .....-ны өдрийн
..... дугаар албан бичгийн хоёрдугаар хавсралт

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ БОЛОН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

2026 оны 01 дүгээр сарын 02 Улаанбаатар хот

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо					Хувийн жин
					ХЗДХЯ	ТТАХНЭ	ДХИС	ХЗТТ	ХЗҮХ	
1	2	3		4	5	6	7	8	9	10
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлтэй нийцүүлэн баталсан эсэх		1	1	1	1	1	1	100
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх		1	1	1	1	1	1	100
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	100
			Соён гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	100
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	100
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	100
Хэсгийн оноо				**4**	4	4	4	4	4	100
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх		1	1	1	1	1	1	100
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан		1	1	1	1	1	1	100

		байдал							
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал	1	1	1	1	0.5	1	100
Хэсгийн оноо			**3**	**3**	**3**	**3**	2.5	**3**	
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал	1	1	1	1	1	1	100
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал	1	1	1	1	1	1	100
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж тайлагнасан байдал	1	1	1	1	1	1	100
Хэсгийн оноо			**3**	**3**	**3**	**3**	**3**	**3**	
Үнэлгээний нийт оноо, хувь			**10**	**10**	**10**	**10**	9.5	**10**	

--- oOo ---

Хууль зүй, дотоод хэргийн яамны
2026 оны 01 дүгээр сарын .....-ны өдрийн
..... дугаар албан бичгийн нэгдүгээр хавсралт

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ БОЛОН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

НЭГ. Товч танилцуулга[1]

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хэрэгжиж эхэлснээр Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/11 дүгээр “Ёс зүйн дэд хороог байгуулж, бүрэлдэхүүнийг батлах тухай” тушаалаар тус яамны дэргэдэх Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, чиг үүрэгтэй Ёс зүйн дэд хороог байгуулсан.

Мөн Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/259 дүгээр “Тушаалд өөрчлөлт оруулах тухай”, 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/181 “Тушаалд нэмэлт оруулах тухай” тушаалаар тус тус бүрэлдэхүүнд өөрчлөлт орж, одоогоор 7 албан хаагч сонгогдон ажиллаж байна. Тус яамны харьяа 4 байгууллага нь дараах бүрэлдэхүүнтэйгээр дэд хороодоо байгуулан ажиллаж байна.

Хууль зүйн туслалцааны төвийн тухайд:

Хууль зүйн туслалцааны төвийн захирлын 2024 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн А/30 дугаар “Ес зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” тушаалаар 5 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр Ёс зүйн дэд хороог байгуулан ажиллаж байна.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн тухайд:

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирлын 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/34 дүгээр “Ес зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг батлах тухай” тушаалаар 5 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр Ёс зүйн дэд хороог байгуулан ажилласан.

Мөн Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирлын 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/23 дугаар “Тушаалд өөрчлөлт оруулах тухай” тушаалаар тус тус бүрэлдэхүүнд өөрчлөлт орж, 5 албан хаагч сонгогдон ажиллаж байна.

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн тухайд:

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн захирлын 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/07 дугаар тушаал “Ёс зүйн дэд хороог байгуулах тухай” тушаалаар 7 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр Ёс зүйн дэд хороог байгуулан ажилласан.

Дотоод хэргийн их сургуулийн тухайд:

Дотоод хэргийн их сургуулийн захирлын 2024 оны А/455 дугаар “Ес зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг батлах тухай” тушаалаар 7 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр Ёс зүйн дэд хороог байгуулан ажилласан.

Хууль зүй, дотоод хэргийн яам болон харьяа байгууллагуудын Ёс зүйн дэд хороод нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон холбогдох хууль, журмын хүрээнд байгууллагын албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хараат бусаар хянан шийдвэрлэх чиг үүрэгтэйгээр шударга, ил тод, нууцлалыг хангасан зарчмаар байгууллагын ёс зүйн соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт, соён гэгээрүүлэх ажлыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна.

Мөн дэд хороод нь хууль, журмаар хүлээсэн үүргийн дагуу жил бүр ёс зүйн дэд хорооны төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэн, тайлан мэдээг Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын https://hrm.csc.gov.mn дэд системд тухай бүр тайлагнан ажиллаж байна.

ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар

2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[2]:

Хууль зүй, дотоод хэргийн яам болон харьяа байгууллагууд нь Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолын хавсралтаар батлсан Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр /2024-2030 он/ -т тусгагдсан яамд, харьяа байгууллагын хяналтад авсан арга хэмжээг тухай бүр үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх ёс зүйн дэд хороо нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд дараах ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлэв. Үүнд:

- Тус яамны Ёс зүйн дэд хорооноос Монгол Улсын Ёс зүйн хороотой хамтран Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулж буй “Шинэтгэлээр түүчээлсэн салбар зөвлөл” аяны хүрээнд “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалтыг 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулсан. Сургалтаар тус зөвлөлийн дэргэдэх Ёс зүйн хорооны Ажлын алба, Соён гэгээрүүлэх хэлтсийн дарга Ц.Заяхүү "Төрийн албан хаагчийн ёс зүй" сэдвээр илтгэл тавьж, сургалтад хамрагдсан 60 гаруй албан хаагчдын мэдлэг, ойлголтыг бататгалаа;
- Ёс зүйн хорооны ажлын албаны Дэд хороо хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Мөнхжингөөс “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”, “Хүний нөөцийн удирдлагын бүртгэл хяналтын систем”-ийн талаар ёс зүйн дэд хорооны бүтэц, чиг үүрэг, үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөв;
- Тус дэд хороо нь 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 3-т "Яаманд гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчил, түүний шалтгаан, эрсдэлийн талаарх мэдээллийг дотоод хяналтын нэгжид тухай бүр хүргүүлэх" талаар тусган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна;
- Тус яамны Төрийн захиргааны удирдлагын газар нь шинээр ажилд орсон ажилтанд зориулсан чиглүүлэх сургалтын агуулгад Төрийн албан хаагчийн баримтлах ёс зүйн хөтөлбөрийг тусган ажиллаж байна. Мөн Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем https://erp.e-mongolia.mn/ цахим сүлжээгээр албан хаагчдад ёс зүйн талаарх мэдээ, мэдээллийг байршуулан, ёс зүйн соёлыг төлөвшүүлэхээр ажиллаж байна;
- ХЗДХЯ Ёс зүйн дэд хороо нэртэй пэйж хаяг үүсгэн тус яамны ажилтан, албан хаагчдын фэйсбүүк групт мэдээ, мэдээллийг байршуулан ажиллаж байна. Тус пэйжийг нээсэнтэй холбоотойгоор албан хаагчдадаа үйл ажиллагааг таниулах зорилгоор Ёс зүйн дэд хороондоо лого хийж ажиллав;
- Тус дэд хороо нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, холбогдох бусад хууль, Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолын хавсралтаар батлсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам", Засгийн газрын 2024 оны 109 дүгээр тогтоолын хавсралтаар батлсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ"-г үйл ажиллагаандаа баримтлан ажиллаж байна;
- Төрийн албаны хүний нөөцийн удирдлага, мэдээллийн тогтолцоо" цахим системд Ёс зүйн гомдол, мэдээлэл, гаргасан дүгнэлт, ёс зүйн хариуцлага тооцсон шийдвэрийг тухай бүр бүртгэн ажиллаж байна.

Хууль зүйн туслалцааны төвийн дэргэдэх ёс зүйн дэд хороо нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд дараах ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлэв. Үүнд:

- Шинээр томилогдсон улсын 9 өмгөөлөгч, захиргааны 3 ажилтан, улсын өмгөөлөгчийн 2 туслахад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Монгол Улсын ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор батлсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”, Өмгөөлөгчийн ёс зүйн дүрэм, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолын хавсралтаар батлсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр (2024-2030 он)”-ийг тус тус танилцуулсан;
- “Эерэг хандлага-эрүүл ажлын орчин” 1 сарын аян зарлаж, 7 хоног тутамд өөр сэдвээр 3 удаа “Талархъя”, “Уучлаарай”, “Цэвэрхэн ширээ-Цэгцтэй сэтгэлгээ” аянуудыг 2025.05.19-2025.06.12 өдрүүдийн хооронд амжилттай хэрэгжүүлсэн;
- Хууль зүйн туслалцааны төвийн нийт албан хаагчдад 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр “Мэргэжлийн ёс зүйн онол, хандлага” сэдвээр Монголын Өмгөөлөгчдийн холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны гишүүн, өмгөөлөгч Б.Өлзийсайхан цахимаар, “Төрийн албан хаагчид тавигдах ёс зүйн нийтлэг

шаардлага” сэдвээр Ёс зүйн дэд хорооны дарга, улсын өмгөөлөгч Л.Мөнхтуяа танхим болон цахим хосолсон хэлбэрээр сургалт явуулсан;

- 2025 оны 05 дугаар сарын 19-23-ны өдрүүдэд зарласан “Эерэг хандлага – Эрүүл ажлын орчин” талархлын аяны хаалтын арга хэмжээг зохион байгуулж, талархал гардуулж, танин мэдэхүйн хөгжөөнт “АХА” тэмцээнийг нийслэлийн албан хаагчдын дунд зохион байгуулсан;
- Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 3.7-д заасны дагуу Улсын өмгөөлөгчийн үйл ажиллагааг сурталчлах, нийгмийн сэтгэл зүйд эергээр нөлөөлөх зорилгоор байгууллагын ёс зүй, харилцаа хандлага, хамт олны хариуцлагыг нэмэгдүүлэх, харилцан ойлголцлыг бэхжүүлэх зорилгоор Ёс зүйн дэд хорооны гишүүд болон бусад албан албан хаагчдыг хамруулж уриалга гаргаж, рийл (контент) хийж байгууллагын сошиал хуудсанд байршуулав;
- Монгол Улсын ёс зүйн хорооны танилцуулга, Төрийн албан хаагчдын ёс зүйн хууль тогтоомжийн эмхэтгэл, Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 109 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ”-г 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр нийт албан хаагчдад албаны мэйлээр мэдээлэл хүргүүлсэн;
- 2025 оны 09 дүгээр сарын 19-ны өдөр Төрийн албан хаагчийн “Ёс зүй ба хүн чанар” сэдвээр Олон нийт, хэвлэл мэдээлэл, Сургалт, судалгаа олон нийттэй харилцах хэлтэстэй хамтран нийт албан хаагчдад танхим болон цахимаар сургалт зохион байгуулав;
- Байгууллагын албан хаагчдын дунд ёс зүйн асуудлын хүрээнд санал хүсэлт, судалгаа авах ажлын хүрээнд нийт 65 албан хаагчийг хамруулан Ёс зүйн сорил тестийг 2025 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр авч, албан хаагчдын ёс зүйн түвшинг үнэлсэн;
- Монгол Улсын Ёс зүйн хорооноос зохион байгуулж уриалсан “Хүндэлье-Энэрье” сарын аянд нийт албан хаагчдыг уриалан оролцуулсан.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн дэргэдэх ёс зүйн дэд хороо нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд дараах ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлэв. Үүнд:

- Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд ёс зүйн сургалт, мэдээлэл, зөвлөмж, дотоод хяналт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, байгууллагын ёс зүйн соёлыг төлөвшүүлэхэд чиглэж ажилласан;
- Ёс зүйн хорооны 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 06 дугаар тогтоолоор батлагдсан аргачлалын дагуу нийт албан хаагчдаас Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлалыг ашиглан байгууллагын хэмжээнд ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээг хийж, дүнг үндэслэн эрсдэлийг бууруулах хариу арга хэмжээний хяналтын хуудсыг гаргасан. Ёс зүйн хорооны 07 дугаар тогтоолоор батлагдсан Ёс зүйн нөлөөллийн мэдүүлгийг албан хаагчдаас гаргуулж ажилласан. Мөн хорооны 08 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, хариуцлагын бүртгэлийн хуудас”-ыг хэвлэн авч, хүний нөөцийн удирдлага мэдээллийн тогтолцоо системд дэд хорооны бүрэлдэхүүний хөдөлгөөнийг бүртгэн ажиллаж байна;
- “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”/2024-2030/-ийн хэрэгжилтийг Монгол Улсын Ёс зүйн хорооны 2025 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт”-д тусгагдсан зорилт, арга хэмжээний хүрээнд нэгтгэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 01/403 тоот албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн дэргэдэх ёс зүйн дэд хороо нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд дараах ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлэв. Үүнд:

- Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэхэд 98,5%-тай дүгнэгдсэн;

- Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн Ёс зүйн дэд хорооны пэйж хуудсыг нээн 2025 оны эхний 9 сарын байдлаар 24 төрлийн нөлөөллийн мэдээллийг оруулсан.Тус пэйж хуудас нь 1,600 дагагчтай байна;
- "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо" цахим системийн бүрэлдэхүүн болох ёс зүйн зөрчил хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлд ёс зүйн зөрчил гаргасан болон сахилгын шийтгэл авсан 2 алба хаагчийг бүртгэсэн;
- Хүний нөөцийн үнэлгээний төвтэй хамтран ажилтан, алба хаагчдын дунд ажилтны хандлага-ур чадвар, эмнэлгийн ажилтны ёс зүй, менежерийн ур чадвар гэсэн гурван төрлөөр үнэлгээ хийсэн бөгөөд нийт 298 ажилтан, алба хаагч хамрагдсан.

Дотоод хэргийн их сургуулийн дэргэдэх ёс зүйн дэд хороо нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд дараах ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлэв. Үүнд:

- Их сургуулийн багш, албан хаагчдад "Монголын төрт ёсны уламжлал, төрийн албаны үнэт зүйл" лекц, “Хувь хүний хөгжил-ёс зүй”, “Харилцаа, хандлага”, “Хувь хүний хөгжил-ёс зүй” сэдэвт сургалтуудыг тус тус зохион байгуулсан;
- Их сургуулийн захирлын 2025 оны А/604 дүгээр тушаалаар 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдөр 2024-2025 оны хичээлийн жилд шинээр томилогдсон нийт 91 албан хаагч, ажилтанд албан тушаалын ажлын байрны чиглүүлэх сургалтыг зохион байгуулж, сургалтын хүрээнд "Байгууллагын ёс зүй, төлөвшил" сэдвээр сургалт явуулсан;
- Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Монгол Улсын Ёс зүйн хорооны дарга, доктор Ц.Амартөгсийг урьж, Их сургуулийн нийт албан хаагчдад “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, журмын талаар”- лекц уншуулсан;
- Албан хаагчдад ёс зүйтэй ажиллах чиглэлээр суут сэтгэгч, алдартнуудын ёс зүйн талаар хэлсэн ишлэл, ёс зүйн хэм хэмжээ таниулах 10 постер, 1 шторк болон ёс зүйн хорооноос ирүүлсэн мэдээ, мэдээллийг Их сургуулийн удирдлага мэдээллийн систем, цахим хуудсаар дамжуулан түгээж нөлөөлөх ажлыг тус тус зохион байгуулсан;
- Их сургуулийн цахим хуудсаар дамжуулан Ёс зүйн дэд хорооны тайлан, шалган шийдвэрлэсэн зөрлийн тоо мэдээ, болон ёс зүй хариуцсан албан хаагчдын мэдээллийг олон нийтэд нээлттэй ил тод байршуулан ажилласан;
- Их сургуулийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиулах, гарч болзошгүй зөрчил, дутагдлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр Их сургуулийн захирал болон дэд бөгөөд цэргийн зохион байгуулалт, аюулгүй байдлын газрын захирлаас 5 удаагийн үүрэг, зөвлөмжийг хүргүүлэн, хэрэгжилтийг тухай бүр тооцож ажилласан;
- “Их сургуулийн эрсдэлийн үнэлгээ хийх журам”-ын дагуу улирал бүр байгууллагын албан хаагчдын ёс зүйн зөрчил, гаргаж болзошгүй үйл ажиллагааны эрсдэлийг тооцон ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үүрэг, зөвлөмжийг хүргүүлж ажилласан;
- Тайлант хугацаанд Их сургууль шинээр томилогдсон 10 албан хаагчийн тангараг өргөх ажиллагааг зохион байгуулсан бөгөөд тангаргийн хуудсанд ёс зүйг мөрдөж ажиллах талаар тусган ажиллав;
- Их сургууль нь “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-өөс 2025 оны хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд 19 ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн хэрэгжилтийг 100 хувь ханган биелүүлж ажилласан.

2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

Хууль зүй, дотоод хэргийн яамны томилох эрх бүхий албан тушаалтан нь ёс зүйн хэм хэмжээг чанд сахин мөрдөж, шударга, ил тод, хариуцлагатай шийдвэр гаргалтаар үлгэрлэн манлайлж ажилласан.

Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын 5.5, 5.9-д заасны дагуу томилох эрх бүхий албан тушаалтан нийт албан хаагчдын 2025 оны ажлын гүйцэтгэлийг үнэлэхдээ ёс зүй, харилцаа, хандлагыг хамт олноор үнэлүүлж, албан хаагчдыг шагнаж урамшуулахдаа ёс зүйн хариуцлага хүлээсэн эсэхийг нэн тэргүүнд харгалзан үзэж шийдвэрлэсэн.

Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг бүхий л талаар дэмжин ажиллаж, Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ын 3.7-д “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д заасан дэд хорооны гишүүдийн урамшууллыг энэ хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3-д заасны дагуу томилох эрх бүхий албан тушаалтан олгоно.” гэж заасны дагуу дэд хорооны гишүүд, нарийн бичгийн даргын урамшууллыг тухай бүр олгон шийдвэрлэсэн.

Хууль зүйн туслалцааны төвийн тухайд:

Тус төвийн албан хаагчдаас иргэдэд хууль зүйн туслалцаа, үйлчилгээ үзүүлэх, харилцахад баримтлах нийтлэг шаардлага, хэм хэмжээг тогтоож, төрийн үйлчилгээг шуурхай, ил тод, чанартай, хүртээмжтэй, үр дүнтэй хүргэх замаар үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх зорилгоор Хууль зүйн туслалцааны төвийн үйлчилгээний стандартыг тус төвийн захирлын 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн А/46 дугаар тушаалаар батлан, мөрдүүлж байна.

Төвийн удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаалын нийт албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэхдээ ёс зүй, харилцаа, хандлагыг хамт олноор үнэлүүлж, албан хаагчдыг шагнаж урамшуулахдаа ёс зүйн хариуцлага хүлээсэн эсэхийг нэн тэргүүнд харгалзан үзэж шийдвэрлэсэн.

Төсвийн шууд захирагч нь Дэд хорооны гишүүдийг урамшуулах, байгууллагын албан хаагчдад ёс зүйн чиглэлээр сургалт зохион байгуулах зэрэгт шаардагдах зардлыг тухай бүр шийдвэрлэсэн.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн тухайд:

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал хууль, ёс зүйн хэм хэмжээг чанд сахин мөрдөж, шударга, ил тод, хариуцлагатай шийдвэр гаргалтаар үлгэрлэн манлайлж ажилласан.

Ингэснээр байгууллагын ёс зүйн соёл, сахилга хариуцлага бэхжиж, албан хаагчдын итгэл, хамтын ажиллагаа сайжрах нөхцөл бүрдсэн.

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн тухайд:

Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг сурталчилж, ёс зүйн зарчим, нийтлэг хэм хэмжээг тогтоох, сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Ёс зүйтэй манлайлагч” нөлөөллийн аяныг зохион байгуулж тэргүүлсэн 3 алба хаагчийг цалингийн 10%-иар шагнаж урамшуулсан.

Дэд хорооны гишүүдийг урамшууллыг тухай бүр олгон, байгууллагын албан хаагчдад ёс зүйн чиглэлээр зохион байгуулах сургалтын зардлыг шийдвэрлэсэн.

Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэхдээ ёс зүй, харилцаа, хандлагыг хамт олноор үнэлүүлж, албан хаагчдыг шагнаж урамшуулахдаа ёс зүйн хариуцлага хүлээсэн эсэхийг нэн тэргүүнд харгалзан үзэж шийдвэрлэсэн.

Дотоод хэргийн их сургуулийн тухайд:

Их сургуулийн захирлын зүгээс Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг бүхий л талаар дэмжин ажиллаж, ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдэд журамд заасан урамшуулал олгох асуудлыг тухай бүр шийдвэрлэн ажиллаж байна.

Мөн нээлттэй харилцаа, илтгэлцлийг бий болгож сонсогч, суралцагч, багш, албан хаагчтай уулзах цагийн хуваарийг баталж, үзэл бодол, шийдвэрлэх шаардлагатай ажил арга хэмжээг боломжит түвшинд, богино хугацаанд шийдвэрлэн ил тод мэдээлж, ёс зүйн зөрчилтэй эвлэрэхгүй байж ёс зүйтэй байх чиглэлээр үлгэрлэн ажиллаж байна.

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

Хууль зүй, дотоод хэргийн яам болон харьяа байгууллагуудын Ёс зүйн дэд хороод нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон холбогдох хууль, журмын хүрээнд байгууллагын албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, ёс зүйн зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авч хянан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх ёс зүйн дэд хорооноос дараах ажлыг хийж хэрэгжүүлсэн. Үүнд:

- Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан, хэрэгжилтийг ханган ажилласан;
- Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан Гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэх үүргийнхээ дагуу 2025 онд тус дэд хороонд хандан гаргасан 4 гомдол, мэдээллийг хянан шалгаж шийдвэрлэсэн. Гомдлын шийдвэрлэлтийн хариуг холбогдох албан хаагчдад хүргүүлж, "Төрийн албаны хүний нөөцийн удирдлага, мэдээллийн тогтолцоо" цахим системд Ёс зүйн гомдол, мэдээлэл, гаргасан дүгнэлт, ёс зүйн хариуцлага тооцсон шийдвэрийг https://hrm.csc.gov.mn/ цахим системд бүртгэсэн;
- Тус яамны https://mojha.gov.mn/ цахим вэб сайтад Ёс зүйн дэд хорооны буланг 6 дэд сэдвийн хүрээнд оруулж, албан хаагчдыг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт, мэдээлэл, холбогдох хууль эрх зүйн акт, гарын авлагыг байршуулсан;
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас өгсөн чиглэлийн дагуу яам, харьяа агентлаг, байгууллагын гомдол мэдээллийн шийдвэрлэлтийн тоон судалгааг нэгтгэн цахимаар холбогдох албан хаагчид хүргүүлсэн;
- Монгол Улсын Ёс зүйн хорооноос өгсөн чиглэлийн дагуу тус яамны https://mojha.gov.mn/ цахим хаягт ёс зүйн зөрчлийн талаарх мэдээллийг байршуулан ажилласан;
- Тус яамны ёс зүйн дэд хорооны даргын санаачилгаар Ёс зүйн хорооны Гомдол хариуцсан референт Мөнхбатаас Ёс зүйн зөрчлийг шалган шийдвэрлэх чиглэлээр Ёс зүйн дэд хорооны гишүүдэд 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр мэргэшүүлэх, сургалт зөвлөгөөг авсан;
- Тус яамны Төрийн захиргааны удирдлагын газар нь шинээр ажилд орсон ажилтанд зориулсан чиглүүлэх сургалтын агуулгад Төрийн албан хаагчийн баримтлах ёс зүйн хөтөлбөрт туссан арга хэмжээг оруулж ажилласан;
- Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем https://erp.e-mongolia.mn/ цахим сүлжээгээр албан хаагчдыг Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйл, Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн Гуравдугаар бүлэгт заасан хориглолт, хязгаарлалт, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 7, 8 дугаар зүйлд тус тус заасан мэдээллийг байршуулан тухай бүр мэдээллэн ажиллаж байна;
- Мөн ХЗДХЯ Ёс зүйн дэд хороо нэртэй пэйж хаяг үүсгэн тус яамны ажилтан, албан хаагчдын фэйсбүүк групт мэдээ, мэдээллийг байршуулан ажиллаж байна. Тус пэйжийг нээсэнтэй холбоотойгоор албан хаагчдадаа үйл ажиллагааг таниулах зорилгоор Ёс зүйн дэд хороондоо лого хийж ажиллав;
- Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга, цагдаагийн хурандаа, хууль зүйн ухааны доктор Н.Мөнхзул "Захиргааны шийдвэр гаргах ажиллагаа" сэдвээр лекц уншихдаа Төрийн албан хаагчийн Ёс зүйн нийтлэг шаардлага, үүрэг, хориглох зүйлсийг бодит жишээнд суурилан 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдөр тус яамны 704 тоот хурлын танхимд сургалт явуулсан;
- Ёс зүйн хорооны Ажлын алба, Соён гэгээрүүлэх хэлтсийн дарга Ц.Заяхүү нь "Төрийн албан хаагчийн ёс зүй" сэдвээр нийт албан хаагчдад 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдөр сургалт орсон;
- Ирсэн гомдол мэдээлэл, холбогдох баримт материалыг Ёс зүйн дэд хорооны гишүүддээ танилцуулахын тулд ethics@mojha.gov.mn цахим и-мэйл хаяг үүсгэн ажиллалаа.

Хууль зүйн туслалцааны төвийн дэргэдэх ёс зүйн дэд хорооноос дараах ажлыг хийж хэрэгжүүлсэн. Үүнд:

- Хууль зүйн туслалцааны төвийн дэргэдэх Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна;
- Дэд хорооны үйл ажиллагааг нээлттэй ил тод байгууллагын цахим хуудас https://lac.gov.mn/ , edoc.mojha.gov.mn-ийн файлын санд байршуулсан;
- Ёс зүйн дэд хорооны гишүүд 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр Монгол Улсын ёс зүйн хорооноос зохион байгуулсан чадавхжуулах цахим сургалтад хамрагдсан;
- Төрийн албаны зөвлөл, Ёс зүйн хороо, Төрийн албаны зөвлөлийн нийслэл дэх салбар зөвлөлөөс 2025.05.28-2025.05.29-ний өдрүүдэд зохион байгуулсан "Бүсчилсэн хөгжил-төрийн албаны манлайлал" нийслэлийн зөвлөгөөнд Ёс зүйн дэд хорооны дарга Л.Мөнхтуяа оролцов;
- Хууль зүй, дотоод хэргийн яамны 2025 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 3/1158 дугаар албан бичгийн дагуу Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд тусгагдсан хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг гарган хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тус төвийн 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 01/365 дугаар албан бичгээр хариуг хүргүүлсэн.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн дэргэдэх ёс зүйн дэд хорооноос дараах ажлыг хийж хэрэгжүүлсэн. Үүнд:

- 2025.06.19-2025.07.09 өдрүүдэд “Эерэг харилцаа-Эрүүл орчин”, "Эрүүл бие-инээд баясал" аяныг нийт албан хаагчдын дунд эрүүл мэнд, биеийн дархлаа, сэтгэлийн эрүүл байдлыг дэмжих, инээд баясал, эерэг харилцааг нэмэгдүүлэх, ёс зүйн соёлыг бэхжүүлэх зорилгоор 2025.11.28-2025.12.05 өдрүүдэд зохион байгуулсан;
- Төрийн албаны зөвлөлийн дэргэдэх Ёс зүйн хорооны гишүүн, доктор (Ph.D), дэд профессор М.Цэрэнбатыг урьж, 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдөр "Төрийн албан хаагчийн ёс зүй ба эрүүл мэнд", “Стресс менежмент” сэдвээр тус тус лекц уншуулсан;
- Filo Bianco LLC marketing seniour Kreativ Arc Studio& Agency Founder багш Б.Үенчийг урьж, 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдөр “Харилцааны соёл ба хамт олны эрүүл орчин” сэдвээр тус тус лекц уншуулсан;
- Ёс зүйн сургагч багш, "Далд оршихуй" НҮТББ-ын тэргүүн, хүний их эмч Б.Пүрэвжав 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр "Эрүүл оршихуй ба ёс зүй" сургалтыг тус тус орж нийт албан хаагчид хамрагдсан;
- 2025.12.01-2025.12.04 өдрүүдэд Монгол Улсын Ёс зүйн хороо, Удирдлагын академийн хамтран зохион байгуулсан "Ёс зүйн сургагч багш бэлтгэх" сургалтад ёс зүйн дэд хорооны гишүүн, Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга хамрагдаж, гэрчилгээ авсан.

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн дэргэдэх ёс зүйн дэд хорооноос дараах ажлыг хийж хэрэгжүүлсэн. Үүнд:

- Эмнэлгийн ёс зүйн дэд хорооны 2025 онд хийх ажлын төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 23 арга хэмжээг төлөвлөн, 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдөр баталж, хэрэгжилтийг дүгнэхэд 96%-тай байсан;
- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх арга хэмжээний хүрээнд 5 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 680 алба хаагчдыг хамруулсан;
- Ёс зүйн дэд хорооноос 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр Хувь хүний хөгжлийн институттэй хамтран “Хүний хөгжил ба Нийгмийн хөгжил” сэдвээр сургалт зохион байгуулахад 120 гаруй алба хаагч хамрагдсан;
- МҮХАҮТ-ийн бизнес академийн төвөөс Д.Ерөө багш “Ёс зүйтэй манлайлагч” сэдэвт сургалтыг 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулж, 75 алба хаагчид хамрагдсан;
- Хүний нөөцийн судалгааны үндэсний хүрээлэн 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдөр Г.Тэгшбүрэн “Монгол ёс суртахууны сургаал ба Мэргэжлийн ёс зүй” сэдвээр сургалт зохион байгуулахад нийт 123 алба хаагч хамрагдсан;
- Ёс зүйн дэд хорооноос алба, тасаг, төв тус бүр дээр хийгдэх хууль эрх зүйн мэдлэг олгох сургалтын хуваарийн дагуу 2025 оны III улиралд “Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, зарчим”, “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, зарчим”, “Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам” зэрэг сэдвээр нийт 6 удаагийн сургалт

зохион байгуулж, 44 алба хаагчдыг хамруулсан;

- Хөдөлмөрийн дотоод журмын 9 дүгээр зүйлийн 9.3.2-т заасны дагуу “Шинэ ажилтны дасан зохицох үйл ажиллагааны журам”-ын хүрээнд, чиг баримжаа олгох сургалт буюу “Шинэ ажилтны чиглүүлэх хөтөлбөр”-ийн дагуу 2025 онд шинээр ажилд орсон нийт 56 алба хаагчид “Skill up” программаар болон танхимаар “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм”, “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай” хуулиар хичээл сургалт орсон;
- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо Олон улсын магадлан итгэмжлэлийн явцын үнэлгээнд цахим болон газар дээрх үнэлгээ хосолсон хэлбэрээр хамрагдсан;
- Ёс зүйн зөрчилгүй тухай тодорхойлолтыг 2025 онд нийт 46 албан хаагчдад гарган өгсөн;
- Удирдлагын академитай хамтран Ёс зүйн кредиттэй сургалтыг 2025 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулж нийт 82 алба хаагч хамрагдсан;
- Монгол Улсын Ёс зүйн хороонд 2025 оны 07 дугаар сарын 30-ны өдөр Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн Ёс зүйн дэд хорооны 2025 оны эхний хагас жил хийсэн ажлын тайланг гарган 17 дугаар албан бичгээр хүргүүлсэн;
- Монгол Улсын Ёс зүйн хороонд 2025 оны 08 дугаар сарын 05-ны өдөр “Санал хүргүүлэх тухай” 18 дугаар албан бичгийг төлөвлөн хүргүүлсэн;
- Хууль зүй дотоод хэргийн яам 2025 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр ирүүлсэн 3/1158 дугаар “Хэрэгжилт ирүүлэх тухай” албан бичгийг хэлэлцэн биелэлтийг гарган МУ-ын Ёс зүйн хорооны “Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт батлах тухай” 2025 оны 04 дүгээр тогтоолын дагуу биелэлтийг хүргүүлсэн.

Дотоод хэргийн их сургуулийн дэргэдэх ёс зүйн дэд хорооноос дараах ажлыг хийж хэрэгжүүлсэн. Үүнд:

- Их сургуулийн 2025 оны сахилга, ёс зүйн зөвлөгөөнийг зохион байгуулж хорооны 2025 оны үйл ажиллагааны тайланг 500 гаруй албан хаагчид танилцуулж, Их сургуулийн удирдлагаас үүрэг чиглэл өгсөн;
- Албан хаагчдад ёс зүйтэй ажиллах чиглэлээр суут сэтгэгч, алдартнуудын ёс зүйн талаар хэлсэн ишлэл, ёс зүйн хэм, хэмжээ таниулах 10 постер, 1 шторк болон ёс зүйн хорооноос ирүүлсэн мэдээ, мэдээллийг Их сургуулийн удирдлага мэдээллийн систем, цахим хуудсаар дамжуулан түгээж нөлөөлөх ажлыг тус тус зохион байгуулсан;
- Их сургуулийн цахим хуудсаар дамжуулан Ёс зүйн дэд хорооны тайлан, шалган шийдвэрлэсэн зөрлийн тоо мэдээ, болон ёс зүй хариуцсан албан хаагчдын мэдээллийг олон нийтэд нээлттэй ил тод байршуулан ажилласан;
- "Төрийн албан хаагчийн мэргэжлийн ёс зүй, харилцаа, хандлага" сэдэвт оюутан, сурагчдын эрдэм шинжилгээний хурлыг танхим, цахимаар үндсэн болон салбар хуралдаантайгаар зохион байгуулж, хурлын үр дүнг Их сургуулийн Олон нийттэй харилцах төвтэй хамтран цахим хуудас болон олон нийтийн сүлжээгээр мэдээлсэн;
- Их сургуулийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиулах, гарч болзошгүй зөрчил, дутагдлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр Их сургуулийн захирал болон дэд бөгөөд цэргийн зохион байгуулалт, аюулгүй байдлын газрын захирлаас 5 удаагийн үүрэг, зөвлөмжийг хүргүүлэн, хэрэгжилтийг тухай бүр тооцож ажилласан;
- Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдээлэл хүлээн авах зорилгоор гомдол мэдээллийг цахимаар ирүүлэх боломжийг бүрдүүлж www.gov.mn цахим хуудсанд “Гомдол мэдээлэх” цэсийг нээн ажиллуулж байна;
- “Их сургуулийн эрсдэлийн үнэлгээ хийх журам”-ын дагуу улирал бүр байгууллагын албан хаагчдын ёс зүйн зөрчил, гаргаж болзошгүй үйл ажиллагааны эрсдэлийг тооцон ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үүрэг, зөвлөмжийг хүргүүлж ажилласан;
- Дотоод хэргийн их сургуулийн дэргэдэх Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулсан 2 удаагийн сонгон шалгаруулалтын үйл ажиллагаанд ёс зүйн дэд хорооноос төлөөлөл оролцож ажил горилогчдоос Ёс зүйн тухай хууль, журмын мэдлэг, хувь хүний төлөвшил, зан үйлийг тодорхойлох ярилцлагыг зохион байгуулан ажилласан;
- Тайлант хугацаанд Их сургуульд шинээр томилогдсон 10 албан хаагчийн тангараг өргөх ажиллагааг зохион байгуулсан бөгөөд тангаргийн хуудсанд ёс зүйг мөрдөж ажиллах талаар тусгасан байна;

- 2025 онд ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн 1 албан хаагчид ёс зүйн хэм хэмжээг баримталж ажиллах, холбогдох хууль, дүрэм журмыг судлуулах талаар нэгжийн удирдлагад Ёс зүйн дэд хорооны даргын 2025 оны 04/700 дугаар албан бичгээр зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийг дүгнэж ажилласан;
- Ёс зүйн дэд хорооны улирлын үйл ажиллагааны үр дүнг харгалзан хуульд заасан урамшууллыг улирлын ажлын үр дүнг харгалзан олгож, ёс зүйн зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагааг хараат бусаар гүйцэтгэх боломжийг бүрдүүлэн ажиллалаа;
- www.gov.mn дахь Их сургуулийн цахим хуудасны Ёс зүйн дэд хороо цэсээр дамжуулан ёс зүйн хариуцлага тооцсон талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй ил тод байршуулж ажилласан.

Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэд Ёс зүйн дэд хороо байгуулагдсанаар байгууллагын албан хаагчдын дунд маргаан даамжрах, бусдын нэр хүндэд сөргөөр нөлөөлөх эрсдэл буурч, ёс зүйн зөрчлийг газар дээр нь шуурхай шийдэх, хурдан арга хэмжээ авах нөхцөл боломж бүрдсэн. Мөн албан хаагчдад ёс зүйн тухай хууль эрх зүй, хэм хэмжээний талаарх ойлголт, сургалт, мэдээллийг тогтмол өгснөөр сахилга бат, хариуцлага сайжирч, аливаа ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх боломж бүрдсэн. Хууль зүйн туслалцааны төвийн ёс зүйн дэд хороо нь нийт албан хаагчдад Монгол Улсын ёс зүйн хорооны танилцуулга, Төрийн албан хаагчдын ёс зүйн хууль тогтоомжийн эмхэтгэл, Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 109 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ”-г хүргүүлэн ажиллаж, мөн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нөлөөллийн арга хэмжээг сурталчлан таниулж, ёс зүйн зөрчилгүй хүний эрхийг дээдэлдэг соёлч хамт олон болсон. 2025 онд байгууллагын албан хаагчдаас ёс зүйн алдаа зөрчил гарсан талаар гомдол, мэдээлэл ирүүлээгүй нь байгууллагын ёс зүйн дэд хорооны нөлөөллийн арга хэмжээ, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлуудыг хийж гүйцэтгэсний үр дүн гэж үзэж байна. Хууль зүйн үндэсний хүрээлэн албан хаагчдынхаа дунд эрүүл мэнд, биеийн дархлаа, сэтгэлийн эрүүл байдлыг дэмжих, инээд баясал, эерэг харилцааг нэмэгдүүлэх, ёс зүйн соёлыг бэхжүүлэх зорилгоор 2 удаа аян зохион байгуулж ажилласнаар тус хүрээлэнгээс 2025 онд ёс зүйн зөрчилд холбогдсон албан хаагч байхгүй болно. Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг сурталчилж, ёс зүйн зарчим, нийтлэг хэм хэмжээг тогтоох, сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Ёс зүйтэй манлайлагч” аяны удирдамж боловсруулж,	Хууль зүйн туслалцааны төвийн ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд албан хаагчдад чиглэсэн үйл ажиллагаа явуулахад санхүүжилт байдаггүй тул зарим ажил, арга хэмжээг зохион байгуулах боломжгүй байдаг. Ёс зүйн бэлтгэгдсэн сургагч багш байхгүй тул Ёс зүйн багц цагийн сургалтыг зохион байгуулах боломжгүй байдалд хүрч байна.

2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эмнэлгийн захирлаар батлуулан алба хаагчдын дунд нээлттэй сонгон шалгаруулалт явуулсан. Үүний үр дүнд Ёс зүйтэй манлайлагч алба хаагчаар Эрүүл мэндийн төвийн эмч, ахлах дэслэгч Ч.Тогтохбаяр, Мэс заслын төвийн их эмч, дэд хурандаа Н.Насантуяа, Эрчимт эмчилгээ мэдээгүйжүүлэг хагалгааны тасгийн эмч, хошууч Т.Мөнхбат нар тус тус шалгарсан. Дотоод хэргийн их сургууль нь Ёс зүйн зөрчилгүй ажиллах зорилгоор зохион байгуулсан сургалт нөлөөллийн арга хэмжээ, урьдчилан сэргийлэх үүрэг, зөвлөмж хүргүүлж ажилласны дүнд ёс зүйн хууль, холбогдох журам, хэм хэмжээний талаарх албан хаагч, сонсогч, суралцагчдын мэдлэг, ойлголт нэмэгдэж зөрчил мэдээлэх тоо нэмэгдсэн ч сахилга, ёс зүйн зөрчлийн тоо тайлант оны байдлаар өмнөх оноос 6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.	
Санал:	
Хууль зүй, дотоод хэргийн яам болон харьяа байгууллагуудын ёс зүйн дэд хороодоос дараах саналыг хүргүүлж байна. Үүнд: - Төрийн албаны зөвлөлийн дэргэдэх Ёс зүйн хорооны жил бүр төрийн байгууллагуудад газар дээр нь очиж зохион байгуулдаг Төрийн албан хаагчийн ёс зүйн мэдлэг мэдээллийг дээшлүүлэх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтын төлөвлөгөөнд тус яам болон харьяа байгууллагуудын албан хаагчдыг хамруулах; - Сургагч багш бэлтгэх сургалтад тус яам болон харьяа байгууллагуудын ёс зүйн дэд хорооны гишүүдийг хамруулах саналтай.	

Шалгах хэсэг:

- ☐ “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- ☐ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- ☐ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан


Төрийн нарийн бичгийн дарга _____ Н.МЯГМАР
/Албан тушаал/ */Гарын үсэг/* */Гарын үсгийн тайлал/*

Ёс зүйн дэд хорооны дарга
ТЗУГ-ын ахлах шинжээч _____ Ю.АЛТАНЦЭЦЭГ
/Албан тушаал/ */Гарын үсэг/* */Гарын үсгийн тайлал/*

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга
ХШДАГ-ын ахлах мэргэжилтэн _____ Б.СУВД-ЭРДЭНЭ
/Албан тушаал/ */Гарын үсэг/* */Гарын үсгийн тайлал/*

Огноо: ..... оны ..... сарын .....

БАТЛАВ.
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ДАРГА Ч.НАРАНТУЯА



ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа /I-IV улирал/	Хариуцах албан тушаалтан
ЗОРИЛТ 1. ТӨРИЙН АЛБАН ХААГЧ ЁС ЗҮЙТЭЙ АЖИЛЛАХАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ СУРГАЛТ, НӨЛӨӨЛЛИЙН АЖЛЫГ ИДЭВХЖҮҮЛНЭ							
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг таниулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах	Улсын төсөв	Зохион байгуулах сургалтын тоо	0	2	II,IV улирал	Г.Базаргүр, Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн
2	Төрийн албан хаагчийг соён гэгээрүүлэх чиглэлээр цахимаар сургалт, мэдээллийг байршуулж, албан хаагчдад хүргэх	Улсын төсөв	Мэдээлэл хүргэсэн эсэх (үгүй-0, тийм-1)	0	1	I-IV улирал	Б.Сувд-Эрдэнэ, Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн
3	Яаманд гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчил, түүний шалтгаан, эрсдэлийн талаарх мэдээллийг дотоод хяналтын нэгжид хүргүүлэх	Улсын төсөв	Мэдээлэл хүргүүлсэн эсэх (үгүй-0, тийм-1)	0	1	I-IV улирал	А.Эрдэнэбулган, Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн
ЗОРИЛТ 2. ТӨРИЙН АЛБАНД ЁС ЗҮЙН ЗӨРЧЛИЙГ ҮЛ ТЭВЧИХ СЭТГЭЛГЭЭ, ШУДАРГА БАЙДЛЫГ ЭРХЭМЛЭХЭД ЧИГЛЭСЭН СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ АЖЛЫГ ЭРЧИМЖҮҮЛНЭ							
4	Яаманд шинээр ажилд орсон ажилтанд зориулсан чиглүүлэх	Улсын төсөв	Хүргүүлэх саналын тоо	0	1	I-IV улирал	Ю.Алтанцэцэг, Ёс зүйн дэд хорооны

	сургалтын агуулгад ёс зүйн агуулга хөтөлбөрийг тусгах						бүрэлдэхүүн
ЗОРИЛТ 3. ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭГ САХИУЛАХ, ЗӨРЧЛИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛНА							
5	Ёс зүйн гомдол, мэдээлэл, гаргасан дүгнэлт, ёс зүйн хариуцлага тооцсон шийдвэрийг "Төрийн албаны хүний нөөцийн удирдлага, мэдээллийн тогтолцоо" цахим системд тухай бүр бүртгэх	Улсын төсөв	Бүртгэл хөтөлсөн эсэх (үгүй-0, тийм-1)	0	1	I-IV улирал	Б.Сувд-Эрдэнэ
6	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.6-д заасны дагуу гомдол, мэдээллийг хүлээн авч, хянан шалгаж, шийдвэрлэх	Улсын төсөв	Гомдол мэдээллийн шийдвэрлэлтийн хувь	0	100%	I-IV улирал	Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн
7	Ёс зүйн зөрчлийг шалган шийдвэрлэх чиглэлээр Ёс зүйн дэд хорооны гишүүдийг мэргэшүүлэх, сургалт зөвлөгөө авах	Улсын төсөв	Сургалт зөвлөгөө авсан эсэх (үгүй-0, тийм-1)	0	1	I- II улирал	Ч.Нарантуяа
ЗОРИЛТ 4. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХҮРЭЭНД ДОТООД АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛНА							
8	Дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг хангах	Улсын төсөв	Гүйцэтгэлийн хувь	0	100%	I, IV улирал	Г.Базаргүр, Б.Сувд-Эрдэнэ
9	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбогдох тайлан, мэдээ, үйл ажиллагааны тайланг тогтоосон хугацаанд Ёс зүйн хороонд хүргүүлэх	Улсын төсөв	Тайлан мэдээг хүргүүлсэн эсэх (үгүй-0, тийм-1)	0	1	I-IV улирал	Б.Сувд-Эрдэнэ

10	Гомдол, мэдээллийг шалгах явцад цугларсан холбогдох материалыг архивын асуудал хариуцсан албан хаагчид хүлээлгэн өгөх	Улсын төсөв	Архивын нэгж үүсгэн, хүргүүлсэн эсэх (үгүй-0, тийм-1)	0	1	IV улирал	Б.Сувд-Эрдэнэ

---oOo---